



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/554

Зуунмод

Зардал гаргах тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын PCR шинжилгээ хийх лабораторийн тоног төхөөрөмжийн хил, гааль, ачаа тээвэрлэлтийн зардалд зориулан 6,645,000 (зургаан сая зургаан зуун дөчин таван мянга)-төгрөгийн зардал гаргасугай.

2. Зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (С.Магнайбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Тоног, төхөөрөмжийг суурилуулах зөвөөрлөх ажлыг холбогдох дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэн, хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Сэлэнгэ

*(Handwritten signature)*

13/ix